



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/198

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Засгийн газар болон Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан "Тогтвортой амьжиргаа-III" төслийн санхүүжилтийн хэлэлцээр, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 196 тоот тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тогтвортой амьжиргаа-3 төслийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа болон аймгийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хяналт тавих, сумдыг удирдлагаар ханган ажиллах ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Г.Хэрлэнчулуун	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	Ж.Даваасүрэн	-Төслийн орон нутгийн ажилтан
Гишүүдэд	С.Бат-Эрдэнэ	-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	С.Нямдаваа	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Ц.Дэмбэрэлсайхан	-Орон нутгийн өмчийн газрын дарга
	Ж.Энх-Амгалан	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

2. Тогтвортой амьжиргаа-3 төслийн үйл ажиллагаа болон Аймгийн чадавх бэхжүүлэх багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА